



СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

2016 оны 08 дугаар сарын 01

Дугаар

Улаанбаатар хот

1. Ерөнхий зүйл

Монгол улсын Эрүүл мэндийн хөгжлийн төв (цаашид “ЭМХТ” гэх) ба Бүгд Найрамдах Солонгос Улсын Чунбүг Үндэсний их сургуулийн эмнэлгийн төлөөлөгч “Пи-Эс-Даблью” ХХК (цаашид “Төлөөлөгч” гэх) (хамтад нь “Талууд” гэх) нь харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол улсын Эрүүл мэндийн салбарын менежерүүдийг БНСУ-ын Өвчний хяналтын төв, Үндэсний Эрүүл мэндийн судалгааны хүрээлэн, Эм үйлдвэрлэлийн хүрээлэн, Хүний нөөцийн хөгжлийн хүрээлэн, Чунбүг Үндэсний Их сургуулийн эмнэлгүүдэд удирдлагын сургалтанд хамруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулахад зориулж энэхүү гэрээг байгуулав.

Гэрээ нь талууд гарын үсэг зурж тамга дарснаар хүчин төгөлдөрт тооцогдох бөгөөд аль нэг тал нь цуцлах санал бичгээр гаргасан тохиолдолд хүчингүйд тооцогдоно.

Гэрээний хугацаа 2016 оны 08сарын 01 өдрөөс эхлэн 2016 оны 12 сарын 01 өдөр хүртэлх хугацаанд үргэлжилнэ.

2. Төлөөлөгчийн үүрэг, хариуцлага

- 2.1. Төлөөлөгч нь удирдлагын сургалтанд хамрагдаж байгаа менежерүүдийг хүлээн авч, сургалтыг чанартай зохион байгуулна.
- 2.2. Төлөөлөгч нь сургалтанд хамрагдаж байгаа менежерүүдийг суралцах хугацаанд байрлах байр, хоол, хот доторх унааны, онгоцны буудлаас тосох хүргэх асуудлыг бүрэн хариуцаж шийдвэрлүүлж өгнө.
- 2.3. Төлөөлөгч нь Монгол улсаас суралцагчдыг Солонгос улсад суралцах хугацаанд орчуулагчаар хангах, Солонгос соёлд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлнэ.
- 2.4. Төлөөлөгч нь суралцах хугацааны хөтөлбөрийг сургалт явагдах газруудаас хүлээн авч ЭМХТ-д өгнө.
- 2.5. Төлөөлөгч нь сургалтад хамрагдах менежерүүдийн бүрдүүлэх материал, БНСУ-д зорчих визийн асуудлыг бүрэн хариуцна.
- 2.6. Төлөөлөгч нь сургалтыг доорхи хуваарийн дагуу хариуцан ажиллана.
 - 2.6.1. Сургалт 2016 оны 09 сарын 20-с 2016 оны 09 сарын 25-г дуустал үргэлжлэх бөгөөд энэ туршлага судлах удирдлагын сургалтанд Эрүүл мэндийн байгууллага,



эмнэлгийн удирдлагын багийг бүрдүүлэн нийт 30 менежерийг хамруулна.

3. ЭМХТ-ийн үүрэг хариуцлага

- 3.1. ЭМХТ нь удирлага, туршлага судлах сургалтанд холбогдох чиглэлийн эрүүл мэнд, эмнэлгийн удирдах түвшний менежерүүдийг хамруулна.
- 3.2. ЭМХТ нь удирдлагын сургалтанд хамрагдах менежерүүдтэй сургалтын гэрээ байгуулна.
- 3.3. ЭМХТ нь сургалтанд хамрагдах менежерүүдийн мэдээллийг Төлөөлөгчид хүлээлгэн өгнө.
- 3.4. ЭМХТ нь сургалтын хугацаанд баримтлах сургалтын нэгдсэн удирдамж боловсруулна.
- 3.5. ЭМХТ нь суралцагчдад онгоцны тийз захиалах ажлыг хариуцна.

4. Төлбөр, тооцоо

- 4.1. Удирдлагын багийн сургалтыг зохион байгуулах зардал нь нэг хүний 610.000 KRW бөгөөд 30 хүний зардал нь нийт 18.300.000 KRW болно. Сургалтанд шаардагдах зардлыг гэрээний дагуу “Пи-Эс-Даблю” ХХК-ийн дансанд шилжүүлэх буюу ЭМХТ-ийн кассаар баримт үйлдэн шилжүүлнэ.
- 4.2. Гэрээ байгуулж БНСУ-ын элчинд виз мэдүүлсний дараа 4.1-т заагдсан сургалтын зардлын урьдчилгаа 50 хувийн төлбөрийг, сургалтанд хамрагдах тухай тушаал, шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдөрт багтаан үлдсэн 50 хувийн төлбөрийг шилжүүлж тооцоо хийнэ.
- 4.3. ЭМХТ нь энэхүү гэрээний дагуу үргэлжлүүлэн суралцуулах захиалга өгсөн тохиолдолд дээрх үнийг баримтална.

5. Бусад зүйл.

- 5.1. Гэрээнээс үүдэлтэй аливаа маргаан гарвал Талууд хэлэлцээний замаар шийдвэрлэх боломжит бүхий л арга хэмжээг авна. Хэрэв уг арга хэмжээ нь зохих үр дүнд хүрэхгүй бол хуульд заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 5.2. Гэрээнд талууд тохиролцон бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 5.3. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэх бөгөөд эхүүд нь нэгэн адил хүчинтэй байна.

6. Талуудын хууль ёсны хаяг

Эрүүл мэндийн хөгжлийн төв
Хаяг: СБДүүрэг 1-р хороо Энхтайван 13в
Утасны дугаар: 976-11-70128801
Факс: 976-11-320633

“Пи-Эс-Даблю” ХХК-ний
Хаяг: СБДүүрэг 1-р хороо Нийслэлийн
Өргөө амаржих газар
Утасны дугаар: 976-91998109, 9505-4415

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“Пи-Эс-Даблю” ХХК-ний
Менежер *Түндэсавдал*

ЭМХТ-ийн мэргэжилтэн